

БӨӨРНИЙ АРХАГ ӨВЧНИЙ ҮЕД ЭМНЭЛЗҮЙД ГАРАХ ӨӨРЧЛӨЛТИЙГ ХҮРЭЛЦЭХ ШИНЖИЛГЭЭНИЙ АРГААР СУДЛАХ НЬ

Алтансүх Ичинноров^{*1}, Намтар Төгөлдөр¹, Баасан Мөнхдэлгэр¹, Ядмаа Өнөржаргал¹
Халзаабааст Туул², Энхболд Энхсүрэн³

¹Синдүра-мед эмнэлэг, Эмзүйн Шинжлэх Ухааны Их Сургууль

²Оточ Манрамба Их Сургууль

³Монгол Анагаах Ухааны Төв Эмнэлэг, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль

*цахим шуудан: ichinnorov.alt@monos.mn

THE CLINICAL STUDY ON DIAGNOSIS OF CHRONIC KIDNEY DISEASE USING THE METHOD OF PALPATION

Ichinnorov Altansukh*, Togoldor Namtar¹, Munkhdelger Baasan¹, Unurjargal Yadmaa¹,
Tuul Khalzaibaast², Enkhsuren Enkhbold³

¹ Sindura-Med hospital of Mongolian University of Pharmaceutical Sciences

²Department of Traditional Medicine, Otoch Manramba University

³ Mongolian Traditional Medicine of Mongolian Traditional Central Hospital of the International School

*email: ichinnorov.alt@monos.mn

Abstract

Background: According to the Health Indicators 2023, diseases of the genitourinary system have ranked fourth among the causes of diseases of the population over the past 10 years, accounting for 10.2% of all diseases. The incidence of genitourinary tract infections by age group compared with 2014 increased by 997 cases in 2023 for all ages, and the highest increase by 2455.9 cases in those over 65 years of age. Therefore, early detection, diagnosis, and prevention of kidney disease are important.

Material and method: The study included 40 adult persons who were hospitalized with chronic kidney disease at Sindura-med hospital in 2023-2024. We studied the clinical observation in chronic kidney disease using the pulse palpation, point palpation method of traditional medicine, and Pasternatsky's symptom palpation of Western medicine.

Result: At Sindura-med hospital, all patients diagnosed with chronic kidney disease had cold character pulse reading symptoms and pain on the kidney points of traditional medicine. Eye swelling is a common symptom in chronic kidney disease, but 17,5 percent of the study participants experienced eye swelling.

The majority, 52.5% of all inpatients, and 57.1% of women inpatients had on both sides plus Pasternatsky's sign, which is a painful sensation when palpating the kidney area, but 45.5% of men inpatients had positive Pasternatsky sign on the right side.

Conclusion: According to traditional medical theory, when a disease has been going on for a long time, a cold pulse will be detected through pulse reading diagnosis. In kidney disease, a positive Pasteur's sign, which is pain felt on palpation in the area, is a key diagnostic indicator.

Keywords: Chronic kidney disease, Palpation, Pulse reading diagnosis, Pasternatsky's sign.

Судалгааны ажлын үндэслэл

Эрүүл мэндийн үзүүлэлт 2023-д сүүлийн 10 жилд шээс бэлгийн тогтолцооны өвчлөл нь амбулаторийн өвчлөлийн дөрөвдүгээр байранд орж, нийт өвчлөлийн 10.2%-ийг эзэлж байгаа талаарх үзүүлэлт гарсан. Шээс бэлгийн тогтолцооны өвчний түвшнийг насны

бүлгээр ангилан 2023 оны үзүүлэлтийг 2014 онтой харьцуулахад бүх насны ангилалд уг тогтолцооны өвчин нэмэгдсэн ба 65-аас дээш насанд хамгийн их буюу 2455.9 болж, 2014 оны үзүүлэлтээс 997.0-оор нэмэгдсэн байна.¹ Иймд бөөрний өвчнийг эрт илрүүлэх, оношлох, бөөрний өвчлөлөөс сэргийлэх, бөөрний архаг

өвчний хүндрэлээс сэргийлэх, нас баралтыг бууруулах нь эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг болж байна.

Бөөрний өвчний оношилгоо, эмчилгээ, заслын тухай уламжлалт анагаах ухаанд эх бичгийн судалгаа нэлээд хийгджээ.²⁻⁸ Харин бөөрний өвчний үе дэх оношилгоо, эмчилгээний тухай уламжлалт анагаахын эмнэлзүйн судалгаа манай улсад ховор байна. Тиймээс бид тус сэдвийг сонгон судалсан.

Судалгааны ажлын зорилго:

Бөөрний архаг өвчний эмнэлзүйд гарах өөрчлөлтийг Уламжлалт анагаах ухааны хүрэлцэх шинжилгээний арга болон өрнийн хүрэлцэх шинжилгээний аргаар судлах.⁹⁻¹²

Судалгааны ажлын зорилт:

1. Бөөрний архаг өвчний үед эмнэлзүйд гарах өөрчлөлтийг Уламжлалт анагаах ухааны хүрэлцэх шинжилгээний аргаар судас шинжлэн судлах
2. Бөөрний архаг өвчний үед эмнэлзүйд гарах өөрчлөлтийг Уламжлалт анагаах ухааны хүрэлцэх шинжилгээний аргаар бэлчир орон тэмтрэх шинжлэн судлах
3. Бөөрний архаг өвчний үед эмнэлзүйд илрэх өөрчлөлтийг бодит үзлэгийн тогшилтын аргаар Пастернацкийн шинж тодорхойлон судлах

Судалгааны материал хэрэглэгдэхүүн:

Синдүра-мед эмнэлэгт 2023 онд Бөөрний архаг өвчин оноштой хэвтэн эмчлүүлэгчдэд таниулах зөвшөөрлийн хуудсыг танилцуулан зөвшөөрлийн гарын үсгээр баталгаажуулсан 40 өвчтөн г судалгаанд хамруулсан. ЭЗШУИС-ийн Ёс зүйн хяналтын хорооноос тус сэдвээр судалгааны ажил хийх ёс зүйн зөвшөөрөл авсан болно. Судалгаанд оролцогчдыг дараах шалгуураар сонгов.

Судалгаанд оролцох шалгуур

- Бөөрний архаг өвчин гэж оношлогдсон байх

- Судалгаанд оролцогч 18-аас дээш насны байх
- Монгол улсын иргэн байх

Судалгаанаас хасах шалгуур

- Бөөрний цочмог гэмтэлтэй өвчтөн
- Бөөрний архаг дутагдалтай өвчтөн
- Бөөр шилжүүлэн суулгах мэс засал хийлгэсэн өвчтөн
- Танин мэдэхүйн бэрхшээлтэй өвчтөн
- Судалгаанд оролцохоос татгалзсан тохиолдолд

Судалгааны арга зүй:

Бид уламжлалт анагаах ухааны бэлчир орон тэмтрэх, судас тэмтрэх хүрэлцэх шинжилгээний арга болон өрнийн анагаах ухааны бодит үзлэгийн арга болох тогшилтын аргаар Пастернацкийн шинж буюу бөөрний архаг өвчний үед эмнэлзүйд илрэх өвдөлтийн шинжийн илрэлийг тодорхойлон судалсан.^{12,13} Судалгааны ажлын үр дүнг статистик боловсруулалтын Microsoft Excel-2016, SPSS-22.0 программыг ашиглан боловсруулсан.

Судалгааны ажлын үр дүн

1. Судалгаанд оролцогчдын нас, хүйс




Figure 1. Gender distribution of study participants




Figure 2. Age distribution of the study participants

Зураг 1,2-т үзүүлснээр нийт судалгаанд оролцогчдыг хүйсээр нь авч үзвэл 72% нь эмэгтэй, 28% нь эрэгтэй байсан ба судалгаанд оролцогчдын дийлэнх хувийг эмэгтэйчүүд

эзэлж байна. Насны ангиллын хувьд авч үзвэл нийт судалгаанд оролцогчдын 5% нь 18-20, 10% нь 20-29, 15% нь 40-49, 12% нь 50-59 насныхан тус тус эзэлж байсан бол 60 ба түүнээс дээш насныхан 58%-ийг эзэлж байна. Эндээс харахад 60 ба түүнээс дээш насныхан 58% буюу судалгаанд оролцогчдын дийлэнх хувийг эзэлж байна. Харин 30-39 насныхан судалгаанд хамрагдаагүй байна.

2. Бөөрний архаг өвчний үед эмнэлзүйд гарах өөрчлөлтийг судас шинжлэн үнэлэх аргаар тодорхойлж судалгааны үр дүнг Хүснэгт 1-д харуулав. Бөөрний архаг өвчин оноштой хэвтэн эмчлүүлэгчдийн 57.5%-д нь судас хөндий хоосон, 22.5%-д нь нарийн түргэн доороо хоосон, 20.0%-д нь алгуур дорой байна.

Table 1. Changes detected during pulse palpation in inpatients diagnosed with chronic kidney disease

No	Pulsation pattern	Number	Percentage (%)
1	Valley and empty pulsation	23	57.5%
2	Thing, fast and empty pulsation in bone level	9	22.5%
3	Slow and weak pulsation	8	20.0%

3. Бөөрний архаг өвчний үед эмнэлзүйд гарах өөрчлөлтийг Уламжлалт анагаах ухааны хүрэлцэх шинжилгээний аргаар бэлчир орон тэмтэрч шинжлэх аргаар тодорхойлж судалгааны үр дүнг Хүснэгт 2-т харуулав.

Үүнд эмнэлэгт бөөрний архаг өвчний оношоор хэвтэн эмчлүүлэгчдийн 100% буюу бүгд бөөрний бэлчирт эмзэглэлтэй, 32.5%-д хавангийн өөрчлөлт илэрсэн байна.

Table 2. Changes detected during point palpation in inpatients diagnosed with chronic kidney disease

No	Point	Number	Percentage (%)	Gender	Number	Percentage (%)
1	With pain in the renal point	40	100	Male	11	27.5%
				Woman	29	72.5%
2	Swollen	13	32.5	Male	4	5.0%
				Woman	9	12.5%
3	Unswollen	27	67.5	Male	7	17.5%
				Woman	20	50%

Хавагнах шинж илэрсэн өвчтөнүүдийн хавангийн хэлбэрийг Зураг 3-т харуулав. Судалгаанд хамрагдсан өвчтөнүүдийн 54%

-д зовхи хавагнах шинж тэмдэг, 46%-д хөлийн шилбэ хавагнах шинж тэмдэг илэрч байсан. Үүнээс харахад бөөрний архаг өвчний

оноштой өвчтөнүүдийн дийлэнх буюу 67.5% нь хавангийн шинж тэмдэг илрээгүй байна.

Харин цөөн хувь буюу 32.5% -д хавагнах шинж илэрсэн байна.




Figure 3. Patterns of edema in hospitalized patients with chronic kidney disease

4. Бөөрний архаг өвчний үед эмнэлзүйд илрэх өвдөлтийн шинж буюу См.Пастернацкийг тогшилтын арга ашиглан тодорхойлон Хүснэгт 3-т харууллаа. См.Пастернацкий нийт

судалгаанд оролцогчдын 17.5%-д зүүн талд эерэг, 30%- д нь баруун талд эерэг байсан бол 52.5% буюу дийлэнх нь См.Пастернацкий хоёр талдаа эерэг илрэлтэй гарсан.

Table 3. Pasternatsky's symptom manifestation in inpatients with chronic kidney disease

№	Location of the Pasternatsky symptom	Number	Percentage (%)
1	Pasternatsky's symptom on the right side	12	30%
2	Pasternatsky's symptom on the left side	7	17.5%
3	Pasternatsky's symptoms on both sides	21	52.5%

Пастернацкийн шинжийн илрэлийг хүйсийн хувьд тодорхойлсныг Зураг 4,5-д үзүүлэв. Үүнээс харахад бөөрний архаг өвчин оноштой эрэгтэй хэвтэн эмчлүүлэгчдийн 45.5% буюу дийлэнх хувьд нь См.Пастернацкий баруун

талд эерэг илэрч байсан бол эмэгтэй хэвтэн эмчлүүлэгчдийн 57.1% буюу дийлэнх хувьд нь См. Пастернацкий 2 талд эерэг илэрсэн байна.




Figure 4. Occurrence of Pasternatsky symptom among inpatients with chronic kidney disease




Figure 5. Occurrence of Pasternatsky symptom among female inpatients with chronic kidney disease

Дүгнэлт:

Синдүра мед эмнэлэгт бөөрний архаг өвчин оноштой хэвтэн эмчлүүлэгчдэд УАУ-ы хүрэлцэх шинжилгээний аргаар эмнэлзүйд гарах өөрчлөлтийг судлахад нийт судалгаанд хамрагдсан эмчлүүлэгчдэд хүйтэн өвчний судасны илэрч, бөөрний бэлчир орон эмзэглэлтэй байсан ба цөөн хувь буюу 32.5% нь хавагнах шинж тэмдэг илэрч байсан. Харин Өрнийн анагаах ухааны хүрэлцэх шинжилгээний аргаар шинжлэхэд бөөрний архаг өвчин оноштой нийт хэвтэн эмчлүүлэгчдэд Пастернацкийн шинж эерэг байв. Хүйсийн хувьд авч үзэхэд эмэгтэйчүүдийн дийлэнх буюу 57.1%-д нь Пастернацкийн шинж 2 талд эерэг илэрсэн бол эрэгтэйчүүдийн дийлэнх буюу 45.5%-д нь Пастернацкийн шинж баруун талд эерэг буюу нэг талд илэрч байна.

Судалгааны ажлын хэлцэмж:

С.Сээрсэгдорж нарын Монголын
уламжлалт анагаах ухааны өвчнийг анагаах
увдис /2008/ номонд бөөрний архаг өвчний
үед судас нь нарийн дорой, хоосон алгуур
лугшина гэж бичсэн байдаг бол Анагаах
ухааны дөрвөн үндэст бөөрний архаг өвчний
үед судас нь алгуур, дорой лугшин хэмээн
тэмдэглэжээ. ཁོང་སན་དཀོན་མཆོག་འཕམན་དར་ལྗགས་དག་ཤིག་ཟུང་ས་ཆོགས་ ||
4-р боть /2008/-д судас шээс нь хүйтэн хэмээн
Гоман Гончогпандар тэргүүтэй эрдэмтэд
онцлон бичсэн байна.¹ Харин УАУ-ы зонхилон
тохиолдох өвчний оношилгоо эмчилгээний
эмнэл зүйн удирдамж /2013/-д судас нь
хоосон алгуур лугшина гэж дурджээ. Бидний
судалгааны ажлын үр дүнд судалгаанд
хамрагдсан өвчтөнүүдийн 57.5%-д нь судас
хөндий хоосон, 22.5%-д нь нарийн түргэн
доороо хоосон, 20.0%-д нь алгуур дорой байв.
Эндээс харахад Бөөрний архаг өвчин оноштой
нийт хэвтэн эмчлүүлэгчдийн судсанд хүйтэн

өөрчлөлт илэрсэн нь дээрх сурвалж ном зохиолуудад бичсэнтэй дүйж байна.

С.Сээрсэгдорж нарын Монголын
уламжлалт анагаах ухааны өвчнийг анагаах
увдис /2008/-д бөөрний архаг өвчний үед зовхи
бөлцийж хавагнах, L14 бэлчирт эмзэглэлтэй
шинж илэрнэ гэсэн бол УАУ-ы зонхилон
тохиолдох өвчний, эмчилгээний эмнэл зүйн
удирдамж /2013/-д бөөрний архаг өвчнийг
үзэж шинжлэхэд нүүр нүдний зовхи хавагнана,
нүд бүлцийнэ, нуруу 14-р үе бөөрний бэлчирт
эмзэглэлтэй байна гэж бичжээ. Харин
бидний судалгааны үр дүнд бөөрний архаг
өвчин оноштой өвчтөнүүдэд бөөрний бэлчир
эмзэглэлтэй байсан нь дээрх сурвалж ном
зохиолуудад тэмдэглэсэнтэй дүйж байна.
Харин нийт судалгаанд оролцогчдын 17.5%-
д нь зовхи хавагнасан өөрчлөлт илэрсэн нь
зарим бөөрний архаг өвчин оноштой хүмүүст
зовхи хавагнах шинж илрэхгүй байж болохоор
харагдаж байна.

Х.Гэлэгжамц нарын Бөөр судлал /2010 он/-д Архаг пиелонефрит өвчний үед Пастернацкий шинж нэг талд эсхүл 2 талд илэрч болно гэжээ. Бидний судалгааны үр дүнд нийт судалгаанд оролцогчдын 52.5%-д нь См.Пастернацкий 2 талд, 30%-д нь См.Пастернацкий баруун талд, 17.5%-д См.Пастернацкий зүүн талд илэрсэн нь Х.Гэлэгжамц нарын Бөөр судлал ном нь д дурдсан тэмдэглэлтэй дүйж байна.

Номзүй:

1. Эрүүл мэндийн үзүүлэлт. 312 (2), 135 , 2023.
2. Т. Мөнхзул, С. Энхбаатар, Д. Найдан Бөөрний гэмтсэн халуун, бөөрний архаг өвчний эмчилгээ, уламжлалт анагаах ухаан бакалавр зэрэг горилсон бүтээл, Оточ Манрамба Их дээд сургууль, Улаанбаатар хот, 1-57, 2004.
3. Г.Хишигсүрэн, Б.Аюушжав,

- Б.Болорчимэг Бөөрний хий өвчний эх бичгийн судалгаа, уламжлалт анагаах ухаан бакалавр зэрэг горилсон бүтээл, Оточ Манрамба Их дээд сургууль. Улаанбаатар хот, 1-66, 2018.
4. С.Баярцэцэг, Ч.Дэлгэрмаа, Б.Аюушжав Бөөрний халуун өвчний эх бичгийн судалгаа, уламжлалт анагаах ухаан бакалавр зэрэг горилсон бүтээл, Оточ Манрамба Их дээд сургууль. Улаанбаатар хот, 1-68, 2018.
5. Г.Хурцбилэг, Бөөрний архаг өвчний эх бичгийн судалгаа. 1-72, 2018
6. А.Сундуйжамц, Бөөрний өвчний ялган оношилгоо. 1-82, 2022.
7. Б.Ууванбаатар Б.Аюушжав, УАУ-ы Бөөрний өвчний эм, заслын эх бичгийн судалгаа. 1-93, 2022.
8. Ж.Тамир, Т.Ариунаа, «Монголын анагаах ухаан “Бөөрний архаг өвчин: тодорхойлолт, ангилал, онош, эмчилгээний орчин үеийн асуудлууд. Улаанбаатар хот, 57(5), 53-57, 2007.
9. С.Сээсрэгдорж, Ч.Чимэдрагчаа, С.Хишигжаргал, Д.Цэрэндагва, Д.Чулуунчимэг Монголын уламжлалт анагаах ухааны өвчнийг анагаах увидас. Улаанбаатар хот, 226(1), 159, 2008.
10. Рашааны шим найман гишүүнт нууц увидсын үндэс. 355-366, 2008.
11. УАУ-ны зонхилон тохиолдох өвчний оношилгоо, эмчилгээний эмнэлзүйн удирдамж. Улаанбаатар хот, 232, 2013.
12. Х.Гэлэгжамц, Т.Ариунаа, Ж.Тамир, Д.Энхзаяа, Ж.Энхтуяа, Ж.Ариунболд, Э.Байгалмаа, Бөөр судлал. 193, 2010.
13. С.Сээсрэгдорж, Д.Цэрэндагва Монгол анагаах ухааны өвчнийг шинжилж нотлохуйн нэгдмэл толь. 118-185, 2021.